



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2021/59/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
Чойбалсан хот	бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
2021 он	Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
	Аудитын менежер: И.Сэмжидмаа
	Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Аудитор: Э.Нандинчимэг
	Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд



Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.9. Аудитын илрүүлэлт.....	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	11
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13



1. Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 292

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д. БОЛОРТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баян-Уул сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Баян-Уул сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Баян-Уул сумын цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020264



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,105,122.50	36,329,652.50
35	БАРАА МАТЕРИАЛ	61,105,122.50	36,329,652.50
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	20,000,000.00	-
354	Хангамжийн материал	41,105,122.50	36,329,652.50
35410	Бичиг хэргийн материал	87,500.00	243,500.00
35420	Аж ахуйн материал	34,367,622.50	36,086,152.50
35440	Түлш, шатах тослох материал	6,650,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,833,592,721.94	1,753,531,530.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,833,592,721.94	1,753,531,530.23
392	Биет хөрөнгө	1,795,533,721.94	1,715,625,530.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,762,570,591.37	1,799,470,591.37
39202	Хуримлагдсан элэгдэл	(37,084,311.85)	(181,388,855.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,216,058.00	50,159,093.00
39206	Хуримлагдсан элэгдэл	(22,765,030.86)	(28,956,668.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,268,737.39	43,138,811.89
39208	Хуримлагдсан элэгдэл	(20,430,142.36)	(24,809,525.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	48,082,362.00	76,382,362.00
39215	Хуримлагдсан элэгдэл	(14,324,541.75)	(18,370,277.91)
393	Биет бус хөрөнгө	38,059,000.00	37,906,000.00
39301	Програм хангамж	765,000.00	765,000.00
39302	Хуримлагдсан элэгдэл	(306,000.00)	(459,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,600,000.00	37,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,894,697,844.44	1,789,861,182.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	39,900.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	39,900.00
413	Өглөг	-	39,900.00
4136	Бусад өглөг	-	39,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	39,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,894,697,844.44	1,789,821,282.73
51	Засгийн газрын хувь оролцоо	1,894,697,844.44	1,789,821,282.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	113,747,248.00	113,747,248.00
51101	Өмч: - төрийн	113,747,248.00	113,747,248.00
512	Хуримлагдсан үр дүн	1,580,124,338.88	1,475,247,777.17
51210	Өмнөх үеийн үр дүн	1,580,124,338.88	1,580,124,338.88
51220	Тайланг үеийн үр дүн	-	(104,876,561.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,826,257.56	200,826,257.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	1,894,697,844.44	1,789,861,182.73



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	522,444,000.00	627,570,609.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	490,494,000.00	113,725,026.21
120	Нийтлэг татварын бус орлого	7,852,000.00	78,713,109.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,852,000.00	78,713,109.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,852,000.00	78,713,109.50
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	482,642,000.00	35,011,916.71
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	482,642,000.00	35,011,916.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,950,000.00	513,845,583.29
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	39,606,183.29
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	(35,011,916.71)
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	74,618,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,950,000.00	474,239,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,950,000.00	474,239,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	542,667,091.44	732,493,671.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,667,091.44	712,493,671.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,666,910.44	677,481,754.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,148,696.00	380,604,726.29
210101	Үндсэн цалин	278,037,046.00	294,604,811.29
210102	Нэмэгдэл	23,631,954.00	60,663,942.00
210104	Урамшуулал	38,479,696.00	25,335,973.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,793,000.00	47,533,900.00
210201	Тэтгэврийн даатгал	28,812,668.00	32,323,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,494,909.00	3,802,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,796,106.00	2,986,258.00
210204	Ажилгүйдлийн даатгал	699,202.00	816,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,990,115.00	7,605,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,090,423.00	33,741,346.00
210301	Гэрэл, цахилгаан	5,019,403.00	3,052,846.00
210302	Түлш, халаалт	30,071,020.00	30,190,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	498,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,010,700.00	5,332,990.00
210401	Бичиг хэрэг	809,900.00	555,900.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	364,100.00	593,200.00
210404	Ном, хэвлэл	214,900.00	197,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	75,570.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,121,800.00	3,656,320.00
2105	Нормативт зардал	92,772,590.00	46,305,811.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	308,340.00	250,000.00
210502	Хоол, хүнс	91,855,500.00	45,455,811.00
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	608,750.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,650,000.00	1,138,000.00
210702	Дотоод албан томилолт	1,650,000.00	1,138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,000.00	323,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	112,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	210,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,121,501.44	160,001,181.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	926,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,401,501.44	159,074,301.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181.00	35,011,916.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	181.00	35,011,916.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	181.00	35,011,916.71
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	20,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	20,000,000.00
225102	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	-	20,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,223,091.44)	(104,923,061.71)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(20,223,091.44)	(104,923,061.71)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	514,592,000.00	548,857,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,592,000.00	548,857,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	482,642,000.00	507,490,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	482,642,000.00	507,490,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,950,000.00	41,367,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,950,000.00	41,367,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	514,592,000.00	548,857,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,592,000.00	548,857,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,591,819.00	513,845,583.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,148,696.00	380,604,726.29
210101	Үндсэн цалин	278,037,046.00	294,604,811.29
210102	Нэмэгдэл	23,631,954.00	60,663,942.00
210104	Урамшуулал	38,479,696.00	25,335,973.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,793,000.00	47,533,900.00
210201	Тэтгэврийн даатгал	29,099,300.00	32,323,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,423,400.00	3,802,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,738,700.00	2,986,258.00
210204	Ажилгүйдлийн даатгал	684,700.00	816,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,846,900.00	7,605,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,949,923.00	27,091,346.00
210301	Гэрэл, цахилгаан	5,019,403.00	3,052,846.00
210302	Түлш, халаалт	25,930,520.00	23,540,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	498,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,074,700.00	7,421,700.00
210401	Бичиг хэрэг	828,400.00	665,400.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	364,100.00	593,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,194,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,167,300.00	3,714,000.00
2105	Нормативт зардал	93,175,500.00	46,305,811.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	201,250.00	250,000.00
210502	Хоол, хүнс	91,855,500.00	45,455,811.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,118,750.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,650,000.00	1,138,000.00
210702	Дотоод албан томилолт	1,650,000.00	1,138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,000.00	292,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	112,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	720,000.00	957,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	957,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181.00	35,011,916.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	181.00	35,011,916.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	181.00	35,011,916.71



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	113,747,248.00	200,826,257.56	1,580,124,338.88	0.00	1,894,697,844.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,747,248.00	200,826,257.56	1,580,124,338.88	0.00	1,894,697,844.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,747,248.00	200,826,257.56	1,580,124,338.88	0.00	1,894,697,844.44
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	113,747,248.00	200,826,257.56	1,580,124,338.88	0.00	1,894,697,844.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,747,248.00	200,826,257.56	1,580,124,338.88	0.00	1,894,697,844.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-104,876,561.71	0.00	-104,876,561.71
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,747,248.00	200,826,257.56	1,475,247,777.17	0.00	1,789,821,282.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	514,592,000.00	514,591,819.00	594,296,210.00	513,845,583.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,592,000.00	514,591,819.00	594,296,210.00	513,845,583.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,592,000.00	514,591,819.00	594,296,210.00	513,845,583.29
2101	Цалин хөлд болон нэмэгдэл урамшил	340,148,800.00	340,148,696.00	387,868,100.00	380,604,726.29
210101	Үндсэн цалин	282,690,300.00	278,037,046.00	294,725,700.00	294,604,811.29
210102	Нэмэгдэл	18,978,700.00	23,631,954.00	64,468,900.00	60,663,942.00
210104	Урамшуулал	38,479,800.00	38,479,696.00	28,673,500.00	25,335,973.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,793,000.00	42,793,000.00	48,487,000.00	47,533,900.00
210201	Тэтгэврийн даатгал	29,099,300.00	29,099,300.00	32,972,300.00	32,323,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,423,400.00	3,423,400.00	3,878,700.00	3,802,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,738,700.00	2,738,700.00	3,102,900.00	2,986,258.00
210204	Ажилгүйдлийн даатгал	684,700.00	684,700.00	775,700.00	816,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,846,900.00	6,846,900.00	7,757,400.00	7,605,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,950,000.00	30,949,923.00	38,367,300.00	27,091,346.00
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	5,019,403.00	6,170,000.00	3,052,846.00
210302	Тулш, халаалт	23,450,000.00	25,930,520.00	31,697,300.00	23,540,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	-	500,000.00	498,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,074,700.00	4,074,700.00	7,416,700.00	7,421,700.00
210401	Бичиг хэрэг	800,700.00	828,400.00	454,400.00	665,400.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00	255,000.00	255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,000.00	364,100.00	593,200.00	593,200.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	214,900.00	197,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	2,203,100.00	2,194,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,980,000.00	2,167,300.00	3,714,000.00	3,714,000.00
2105	Нормативт зардал	93,975,500.00	93,974,250.00	106,828,810.00	46,305,811.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,855,500.00	91,855,500.00	216,600.00	250,000.00
210502	Хоол, хүнс	1,120,000.00	1,118,750.00	106,012,210.00	45,455,811.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	600,000.00	600,000.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	2,650,000.00	2,650,000.00	2,500,000.00	2,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00	-	-
210604	Урсгал засвар	1,650,000.00	1,650,000.00	2,500,000.00	2,500,000.00
2107	Томилголт, зочны зардал	-	-	1,378,000.00	1,138,000.00
210701	Гадаад албан томилголт	1,650,000.00	1,650,000.00	-	-
210702	Дотоод албан томилголт	-	-	1,378,000.00	1,138,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	80,000.00	80,000.00	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	480,300.00	292,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	300,300.00	112,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	720,000.00	720,000.00	970,000.00	957,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	720,000.00	720,000.00	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	970,000.00	957,200.00
	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	514,592,000.00	514,591,819.00	594,296,210.00	548,857,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	514,592,000.00	514,591,819.00	594,296,210.00	548,857,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлээс санхүүжих	514,592,000.00	514,591,819.00	594,296,210.00	548,857,500.00



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Уул сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Болортуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 10-аас 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Уул сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баян-Уул сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хичээл сургалтын бэлтгэлийг чанартай хангаж, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, бусад холбогдох Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, цэцэрлэгийн насны хүүхдийг асрах хамгаалах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-Уул сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Баян-Уул сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож,



эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 743,683.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 14,874.0 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-Уул сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,186.6 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	61,105.1	62,979.6	7,874.5
Үндсэн хөрөнгө	1,928,502.7	2,007,515.9	79,013.2
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(94,910.03)	(253,984.33)	(159,074.3)
Нийт хөрөнгө	1,894,697.8	1,816,511.2	(78,186.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	113,747.2	113,747.2	-
Хуримтлагдсан үр дүн	1,780,950.6	1,702,764.0	(78,186.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,894,697.8	1,816,511.2	(78,186.6)

Бараа материалын дансны үлдэгдэл 62,979.6 мянган төгрөг болж 7,874.5 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал, сургалтын хэрэгсэл худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,007,515.9 мянган төгрөг болж 79,013.2 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр отряд бүлгийн цэцэрлэг, бохирын цэвэрлэх байгууламж болон бусад техник хэрэгсэл хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Баян-Уул сумын цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 284,724.47 мянган төгрөгөөр буюу 57.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 61,592.51 мянган төгрөгөөр буюу 41.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 594,296.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 594,296.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.



Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 594,296.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 507,490.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 41,367.3 мянган төгрөгийн нийт 548,857.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 513,854.6 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт буцаан 35,011.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 513,854.6 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байна. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 428,275.8 мянган төгрөг буюу нийт зардлын 83.3 хувийг эзэлж байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 121 мэдээлэл хугацаандаа оруулж, 25 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Батлагдсан төсвийн 572,145.3 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны Санхүүгийн тайлангийн зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь биелүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 131.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 131.9 мянган төгрөгийн зөрчилд 92.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 39.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 131.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 131.9 мянган төгрөгийн зөрчилд 92.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 39.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 92.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Тайлант оны эцэс дэх санхүүгийн тайланд тусгагдсан 39.9 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлсэн баримт үйлдээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.



3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Дорнод аймгийн Баян-Уул сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДОА-2021/59/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорнод аймгийн Баян-Уул сумын Цэцэрлэг	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Нийт 111 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 25 мэдээллийг хоцорч мэдээлсэн байна. Үүнд: 1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) 8,9 сар болон 3-р улирал мөнгөн дүн 572,145.3 мянган төгрөг байна. 2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) 8 болон 9 сар 3. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр) 8 болон 9 сар 4. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 5. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 6. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 7. Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр) 8. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) 8 болон 9 сар 9. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 8 болон 9 сар 10. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн	0.0	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Ц.Болор



	мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) 8 болон 9 сар 11. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) 8 болон 9 сар 12. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) 8 болон 9 сар 13. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр) 8 болон 9 сар				
2	Санхүүгийн байдлын тайлангаар 39.9 мянган төгрөгийн өглөгтэй. Тооцоо нийлсэн акт байхгүй.	39.9	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Ц.Болор
3	Батлагдсан төсөв 163.0 мянган төгрөг ба гүйцэтгэлээр зарцуулсан нь 255.0 мянган төгрөг байна. Тухайн шатахуун зарцуулалтын үндэслэх нотлох баримт хангалтгүй байсан. Шатахуун үндэслэлгүй илүү зарцуулсан дүн 92.0 мянган төгрөг.	92.0	Төлбөрийн акт тогтоох	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Ц.Болор
ДҮН		131.9			